Golomt Capital

# БОНДЫН

## ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ



2025.05.21

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БОНД

| Нэр | Дуусах хугацаа | Купон | Өгөөж |
|---|---|---|---|
| Номад | 2026.04.07 | 5.125% | 6.03% |
| Монгол 27 | 2027.07.07 | 3.50% | 6.76% |
| Хүннү | 2028.01.19 | 8.65% | 6.59% |
| Монгол 29 | 2029.06.05 | 7.875% | 7.06% |
| Монгол 30 | 2030.02.25 | 6.625% | 7.03% |
| Монгол 31 | 2031.07.07 | 4.45% | 7.07% |

*Эх сурвалж: Bloomberg*

Монгол Улсын Засгийн газар бондуудын өгөөж 6.03%-7.07% хооронд хэлбэлзэж байна.

## КОМПАНИЙН БОНД (АМ.ДОЛЛАР)

| Нэр | Дуусах хугацаа | Купон | Өгөөж |
|---|---|---|---|
| Голомт Банк (GLMT) | 2027.05.20 | 11.00% | 9.34% |
| МИК (MIK) | 2027.01.18 | 11.50% | 12.15% |
| TDBM | 2027.12.23 | 8.5% | 9.95% |
| DBM | 2026.03.07 | 11.00% | 8.13% |

*Эх сурвалж: Bloomberg*

Компанийн ам.долларын бондуудын өгөөж 8.13%-12.15%-ийн түвшинд хэлбэлзэж, эрсдэлийг давж өндөр өгөөж хайж буй хөрөнгө оруулагчдын сонирхлыг татаж байна. Голомт Банк олон улсын зах зээлд жилийн 11%-ийн хүүтэй, 2027.05.20-нд хаагдах 300 сая ам.долларын бондыг амжилттай гаргасан бөгөөд хоёрдогч зах зээлийн арилжаагаар худалдан авах боломжтой хэвээр байна.




GC Бондын супермаркет нь хөрөнгө оруулагчдадаа бэлэн бондын тасагт байгаа 5 сарын хамгийн эрэлттэй бондуудаа санал болгож байна.

- Дэд бүтэц : $10%
- Банк санхүү : ₮20%
- Үл хөдлөх : ₮18%-20%
- Уул уурхай : $11%

# АМ.ДОЛЛАРЫН БОНДЫН СУУРЬ МЭДЭЭЛЛҮҮД

*График 1. АНУ-ын доллар дахь хөрөнгө оруулагчдын хандлага*




Сүүлд хөрөнгө оруулагчид АНУ-ын долларт маш сөрөг хандлага үзүүлж буйгаа илэрхийлж, түүхэн дундажтай харьцуулахад хамгийн ихээр "underweight" буюу *бага жинтэй байршуулалттай* байгаа нь 2006 оны 5-р сараас хойших хамгийн доод түвшинд хүрээд байна.

Энэ нь Холбооны Нөөцийн Сан (Fed)-аас бодлогын хүүг бууруулах хүлээлт болон дэлхийн хөрөнгийн урсгал АНУ-ын хөрөнгөөс холдох чиг хандлагатай уялдаж байгаа юм.

*Эх сурвалж: BofA Fund Manager Survey*

**Moody's АНУ-ын зээлжих зэрэглэлийн үнэлгээг бууруулла**

Дэлхийн тэргүүлэх үнэлгээний агентлагуудын нэг Moody's Investors Service АНУ-ын зээлжих зэрэглэлийг нэг шатаар бууруулан Aaa → Aa1 болгож, улс орны урт хугацааны санхүүгийн эрүүл мэндэд тодорхой "анхааруулах дохио" өглөө.

Moody's-оос мэдэгдэхдээ, АНУ нь:
- Тасралтгүй төсвийн алдагдалтай,
- Өр, хүүгийн түвшин хурдтай өсч буй,
- Түүнчлэн төсвийн бодлогын хэтийн төлөв нь ижил зэрэглэлтэй орнуудтай харьцуулахад "мэдэгдэхүйц муу" байгааг дурдсан байна.

Moody's-оос өмнө Fitch Ratings агентлаг 2023 онд АНУ-ын зээлжих зэрэглэлийг бууруулж байсан бөгөөд тухайн үед тэд:
- Улс төрийн мухардал,
- Өрийн таазны эрсдэл,
- Бодлогын тодорхой бус байдал-ыг онцолж байв.

Уналтын гол шалтгаанууд:
1. Өсч буй халамжийн зардал. Medicare болон Social Security зэрэг нийгмийн халамжийн хөтөлбөрүүдэд ахмад настай хүн амын тоо өсөхийн хэрээр төсвийн дарамт нэмэгдэнэ.
2. Хүүгийн төлбөр огцом өсөж байна. Холбооны өрөнд ногдох хүүгийн зардал өссөөр байгаа нь төсвийн алдагдлыг улам тэлж, төсвийн уян хатан байдлыг багасгаж байна.
3. АНУ-ын өрийн түвшин, хүүгийн харьцаа. Эдгээр үзүүлэлтүүд нь одоогоор хамгийн өндөр зэрэглэлтэй орнуудын дунд хамгийн муу үзүүлэлтүүдийн нэг болжээ.

*График 2. АНУ-ын өр (сүүлийн 25 жилд)*




Сая.доллар*

# БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

## Биржийн бус зах зээлийн долоо хоногийн арилжааны тойм

2025 оны 5-р сарын 12-16-ны өдрүүдэд Биржийн бус зах зээл (ББЗЗ)-д нийт 117,299 ширхэг үнэт цаас арилжаалагдаж, арилжааны нийт дүн 43,649,391,904 төгрөг болон 6,693,311.75 ам.долларт хүрсэн байна.
Үүнээс анхдагч зах зээлд нийт 41,201 ширхэг үнэт цаас 23,480,000,000 төгрөгөөр, мөн 2,330 ширхэг үнэт цаас 5,650,000.00 ам.доллароор арилжаалагджээ. Харин хоёрдогч зах зээлд нийт 76,098 ширхэг үнэт цаас 20,169,391,904 төгрөгөөр, мөн 1,040 ширхэг үнэт цаас 1,043,311.75 ам.доллароор тус тус арилжаалагдсан байна.

*Эх сурвалж: Otc.mn*

## Биржийн бус зах зээлийн бондын өгөөжийн муруй

Бондын өгөөжийн муруй нь зах зээлд гарч буй бондуудын хугацаа болон өгөөжийн хамаарлыг нь илтгэдэг. Өгөөжийн муруйг дараах зорилгоор ашиглах боломжтой. Үүнд:

- Үнэт цаасны өгөөжийн хувь үнэт цаасны хугацаанаас хамааран хэрхэн ялгаатай тогтож байгааг мэдэх
- Шинээр гаргах үнэт цаасны үнэ ханш, өгөөжийг тогтоох жишиг хувь болох
- Бусад бондын өгөөжтэй харьцуулан шийдвэр гаргах боломжийг олгодог юм.

***График 2. Бондын өгөөжийн муруй (2024.10-р сард бодлогын хүү өөрчлөгдсөнөөс хойш)***







